НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2022 оны 12 дугаар сарын 03 Улаанбаатар хот

2.2.ИРГЭДИЙГ НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТООР ХИЧЭЭЛЛЭХ НӨХЦӨЛ БОЛОМЖООР ХАНГАНА.

2.2.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгож, иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.2.1.1.Дүүргүүдийн Биеийн тамир, спортын хорооны бүтцийг боловсронгуй болгож удирдлага зохион байгуулалтыг сайжруулна.



Засгийн газрын тохируулагч агентлаг – Биеийн тамир, спортын улсын хорооноос гаргасан жишиг бүтцийг гаргасан.

Энэ жишиг бүтцийн дагуу нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газар (1), хороод(9)-ын орон тоо (210), бүтэц(2-3 хэлтэс), албан тушаалын тодорхойлолтуудыг батлуулснаар 2022 онд 175 ажилтан, албан хаагч үүнээс биеийн тамирын асуудал хариуцсан 84 мэргэжилтэн ажиллаж улсын төсвөөс 2,306,470(хоёр тэрбум гурван зуун зургаан сая дөрвөн зуун далан мянган) төгрөг зарцуулсан. Биеийн тамир, спортын газар, хороодын ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор 70 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1065 албан хаагч хамрагдсан.

Хэрэгжилт 100%

2.2.1.2.Дүүргүүдийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйчтэй болох асуудлыг шийдвэрлүүлнэ.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар болон дүүргийн биеийн тамир, спортын хороодод биеийн тамир, спортын асуудал хариуцсан 84 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд нийслэлийн 1.539.252 хүн амтай харьцуулж үзэхэд нэг албан хаагчид 18,289 хүн оногдож байгаа нь одоогийн өсөн нэмэгдэж байгаа нийслэлийн хүн амд биеийн тамирын үйлчилгээг хүргэхэд хүрэлцээ хангалтгүй байна.

Иймд анхан шатны нэгжид биеийн тамир, спортын үйлчилгээг хүргэх нөхцөлийг сайжруулахаар санал санаачилга гарган шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд Биеийн тамир, спортын тухай хуульд тусгуулахаар 2021.05.03-нд Биеийн тамир, спортын улсын хороонд, 2022.08.02-нд НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст, 2022.11.21-нд 3/235 тоот албан бичгээр НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст тус тус хүргүүлсэн.



НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРААС ГАРГАЖ БУЙ САНАЛ

2022 оны 11 дүгээр сарын 16 Улаанбаатар хот

№	Холбогдох хууль	Санал	Саналын тайлбар
1.	Биеийн тамир, спортын тухай хууль	Биеийн тамир, спортын тухай хуулийн 8.1.4-д ..... дүүргийн хороодод орон тооны орга зүйч ажилтуулах	Манай байгууллагаас 2017 оны Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд суманд болон дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйчтэй болгохоор санал хүргүүлсэнээс сумдад орон тооны орга зүйч ажилтуулахаар заалгасан. Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодод биеийн тамир, спортын асуудал хариуцсан 74 албан хаагч ажиллаж байгаа нь нийслэлийн 1.539.252 хүн амтай харьцуулахад, нэг албан хаагчид 20.801 хүн ногдож байгаа нь онцгойлон өсөн нэмэгдэж байгаа нийслэлийн хүн амд биеийн тамирын үйлчилгээг хүргэхэд хүрэлцээ хангалттүй байна. Иймд Монгол Улсын хүн амын 49 хувь нь оршин суудаг нийслэл хотын засаг захиргааны анхан шатны нэгжид нутаг дэвсгэрийнхээ иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээг хүргэх орон тооны орга зүйч ажиллуулж биеийн тамир, спортын үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд хүрэлцээ хангалттүй байна.

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.БЯМБАСАЙХАН

САНАЛ, ТАЙЛБАР БИЧСЭН:
ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭР
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН А.НАМУУН

Хаанаас: Нийслэлийн Биеийн тамир спортын газар

Хаана: НЗДТГ-н Ниймийн бодлогын хэлтэс

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөвд санал хүргүүлэх тухай

2022 оны 08 дугаар сарын 02 Улаанбаатар хот

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар болон дүүргийн биеийн тамир, спортын хороонууд биеийн тамир, спортын асуудал хариуцсан 74 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд нийслэлийн 1.539.252 хүн амтай харьцуулж үзэхэд нэг албан хаагчид 20.801 хүн ногдож байгаа нь олоогийн өсөн нэмэгдэж байгаа нийслэлийн хүн амд биеийн тамирын үйлчилгээг хүргэхэд хүрэлцээ хангалттүй байна.

2017 оны Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгад суманд биеийн тамирын арга зүйч ажиллуулахаар тусгасан бөгөөд монгол улсын хүн амын 49 хувь нь оршин суудаг нийслэл хотод орон тооны арга зүйч ажиллуулж биеийн тамир, спортын үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд хүрэлцээ шаардлагатай байна.

Иймд 9 дүүргийн 204 хороодод биеийн тамир, спортын хамтлаг байгуулж хамтлаг тус бүрт орон тооны арга зүйч ажиллуулах асуудлыг хуулийн 8.1.4 дэх заалтад нэмэлтээр тусгаж оруулах саналыг хүргүүлж байна.

№	Хууль	Нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн зүйл, заалт	Санал болгож буй санал
1.	Биеийн тамир, спортын тухай хууль	8.1.4 суманд орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах.	8.1.4 дүүргийн хороо болон суманд орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах.

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.БЯМБАСАЙХАН

САНАЛ, ТАЙЛБАР БИЧСЭН:
ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭР
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН А.НАМУУН

Мөн “Биеийн тамирын хамтлаг”-ийн журам шинэчлэгдэж байгаатай холбогдуулан орон тооны болон орон тооны бус арга зүйч ажиллуулах саналыг 2022.04.04-нд БТСУХ-д тус тус хүргүүлсэн.

Хэрэгжилт 100%

2.2.1.3.Иргэдэд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээг чанаржуулах зорилгоор спортын клубүүдийг магадлан итгэмжлэлд хамруулах ажлыг зохион байгуулна.

БСШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан 2019 оны А/178, А/144 дүгээр тушаалаар “Иргэдэд идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортоор хичээллэх үйлчилгээ үзүүлж буй байгууллагад магадлан итгэмжлэлийн үнэлгээ хийх журам”-ыг батлан 2019 оны 09 дүгээр сараас хэрэгжүүлж эхлүүлэн магадлан итгэмжлэгдсэн спорт клубд хичээллэгч иргэдэд эрүүл мэндийн даатгалын сангаас 1 удаа 60.000 төгрөгийн хөнгөлөлт олгох боломж бүрдэх юм. Эрүүл мэндийн яамнаас эрүүл мэндийн даатгалын сангаас биеийн тамир, спортын чийрэгжилтийн үйл ажиллагаанд олгох хөнгөлөлтийг 2021 оноос түр зогсоож санхүүжүүлэх асуудал тодорхойгүй байна.

Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа сайн дурын үндсэн дээр явагддаг тул спорт клубүүдийг татан оролцуулах зорилгоор нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газар хороод зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллаж, магадлан итгэмжлэлийг эрчимжүүлэх зорилгоор ажлын хэсэг байгуулагдан нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 46 фитнес клуб, 4 спиннинг төвд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлснээр Налайх дүүргийн “Налайх спиннинг” клубийн материалыг 2022.11.14, Сонгинохайрхан дүүргийн Бумбод фитнес клубийн материалыг 2022.11.15-нд Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлсэн.

№	Аж ахуйн нэгжийн нэр	Спортын клубын нэр	Үйл ажилла-гааны чиглэл	Хаяг, байршил		Холбоо барих утас
1.	“Голден Жим” ХХК	“Голден Жим” фитнесс клубын 1 дүгээр салбар	Фитнесс	Улаан-баатар Сүхбаатар дүүрэг	8-р хороо, Тусгаар Тогтнолын ордон, 4 давхарт	77770099
2.	“Хамтдаа урагшаа” ТББ	Zaya’s фитнесс клуб	Фитнесс	Улаан-баатар Сүхбаатар	11-р хороолол, Их тойруу-54 “Чөлөөлт хэвлэл сан” Хэвлэлийн хүрээлэн/-ийн 2 давхарт	77113551 99808336 80009741

3.	“МЧБС” ХХК	Соёл фитнесс клуб	Фитнесс	Улаан-баатар Хан-Уул	3-р хороо, Энгельсийн гудамж-4 Соёл төв	77009966
4.	Эмпайр фитнесс клуб ХХК	Эмпайр фитнесс клуб	Фитнесс	Улаан-баатар Хан-Уул	2-р хороо, Чингисийн өргөн чөлөө 67/1 тоот, Номин Юнайтедын 2 давхарт	99098271
5.	Хан-Уул	Олимпус фитнесс клуб	Фитнесс	Улаан-баатар Хан-Уул	-	99047516
6.	“Голден Жим” ХХК	Голден Жим фитнесс клубын 4-р салбар	Фитнесс	Улаан-баатар Баян-зүрх	26-р хороо, “Sun Shine Vilage” хотхон	77770099
7.	“Их үйлс Үлэмж” ХХК	“Gold’s gym” фитнесс клуб	Фитнесс	Улаан-баатар Баян-зүрх	26-р хороо, Их монгол хороолол, Хүннүгийн гудамж 907 байр, Их Монгол үйлчилгээний төв”-ийн 2 давхарт	77111111
8.	Голден Хүүл ХХК	Голден Жим фитнесс клубын 5 дугаар салбар	Фитнесс	Улаан-баатар Баян-гол	14-р хороо Сансар цетр үйлчилгээний зориулалттай барилгын 5 давхар	77770099
9.	BNK фүүдс	МХМ	Фитнесс	Улаан-баатар Сонги-нохайрхан	Мах импекс ХК байр	98245555
10	Талх чихэр ХХК	Та чи	Фитнесс	Улаан-баатар Сонгино хайр-хан	29-р хороо Талх чихэр ХХК байр	98510248
11	“Ханан фитнесс” ХХК	Ханан жим фитнесс клуб	Фитнесс	Сүхбаатар аймаг	1-р баг Усан спорт сургалтын төвд	96190917
12	“Чандмань Биндэр” ХХК	Максимус фитнесс клуб	Фитнесс	Орхон аймаг Баян-Өндөр сум	Бүрэн бүс баг, 11-р хороо 3-р байр	95091115
13	“Туба” ХХК	Wise gym фитнесс клуб	Фитнесс	Орхон аймаг, Баян-Өндөр сум	Уурхайчин баг, Маргад сургуулийн ард Спорт хорооны Б заалны хажууд /3 давхарт/	99269492 99000913 95352670 85112480

Хэрэгжилт 100%

2.2.1.4.Нийслэлийн иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлж, нийтийг хамарсан томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. /Улаанбаатар Марафон, Иргэдийн Спортын наадам, Төрийн албан хаагчдын наадам гэх мэт/

Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын дараа иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх эрэлт хэрэгцээнд тулгуурлан нийтийг хамарсан 19 арга хэмжээг зохион байгуулж 9563 байгууллагын **441,308** иргэнийг хамруулан Нийслэлийн Засаг даргын захирамжаар 551,636,000 (таван зуун тавин нэгэн сая зургаан зуун гучин зургаан мянган) төгрөгийг зарцуулсан.

Иргэдэд биеийн тамир, спортын хамтлагийн үйлчилгээг хүргэх жишиг бүтэц



1.“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ” АЯН

Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлэх дадал олгох зорилгоор Биеийн тамир, спортын улсын хороотой хамтран улс орон даяар 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 28-ны хугацаанд “Илүүдэл жингүй – Эртэч монгол” аяныг зохион байгуулж нийслэлийн 9 дүүргийн 200 гаруй байршилд 7918 байгууллагын 295,739 иргэнийг хамруулсан.

2.НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ИВЭЭЛ ДОР ИРГЭДЭД ЗОРИУЛСАН “АЛХАЦГААЯ ГҮЙЦГЭЭЕ” ХӨДӨЛГӨӨН

Хөнгөн атлетикийн суурьтай дасгал хөдөлгөөнөөр иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээг хүргэх зорилгоор “Алхацгаая гүйцгээе” хөдөлгөөнийг 2022 оны 03 дугаар сарын 26–наас 11 дүгээр сарын хооронд сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Бямба гаригт өрнүүлж 480 байгууллагын 12,050 иргэн хамрагдсан. Дүүрэг тус бүр өөрийн нутаг дэвсгэрт нийтийн алхалт, биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр хичээллүүлэх ажлуудыг өөр өөрийн онцлогт тохируулан зохион байгуулсан.

3.НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН “ТУРШЛАГА СОЛИЛЦОХ” ӨДӨР

Биеийн тамир, спортын байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, харилцан суралцаж, туршлага солилцох, ажилтан, албан хаагчдыг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх нөхцөл боломжоор хангах зорилгоор “Туршлага солилцох өдөр”-ийг 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт зааланд спортын 3 төрлөөр охион байгуулж 100 гаруй ажилтан, албан хаачид оролцсон.

4.НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН ДУНД ЗОХИОГДОХ “ЭРҮҮЛ АГААР-ЭЕРЭГ ХАНДЛАГА” НЭГДСЭН АЛХАЛТ

Идэвхтэй хөдөлгөөнийг энгийн дасгал болгох алхалтаар хичээллэхэд уриалах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх эрүүл зөв амьдралын дадал хэвшилтэй болгох зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн удирдлагын хэлтэс, хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран НЗДТГ-ын албан хаагчдын дунд “Эрүүл агаар-Еерэг хандлага” сэдэвт нэгдсэн алхалтыг 2022 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Чингэлтэй хайрханы чиглэлд зохион байгууллаа.

Алхалтад Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, Хэлтсийн дарга нар, мэргэжилтнүүд болон Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын төлөөлөл бүхий нийт 50 гаруй албан хаагч оролцлоо.

5.НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН “ХАВРЫН БАЯР” БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ӨДӨРЛӨГ

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдыг дасгал хөдөлгөөнөөр хичээллэх идэвхийг өрнүүлэх, биеийн тамир, спортын төрлүүдийг сурталчлан таниулах зорилгоор “Хаврын баяр” биеийн тамир, спортын өдөрлөгийг 2022 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Жаргалантын ам “Чингис Хааны Хүрээ” аялал жуулчлалын цогцолборт спортын 5 төрлөөр зохион байгуулж 25 байгууллагын 600 гаруй ажилтан, албан хаагчид оролцлоо.

6.УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДҮҮДИЙН УРАН ХӨДӨЛГӨӨН

Сургуулийн өмнөх насны хүүхдийн бие бялдрыг гимнастикийн дасгал хөдөлгөөнөөр хөгжүүлэх, тэднийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор цэцэрлэгийн хүүхдүүдийн Уран хөдөлгөөнт гимнастикийн аварга шалгаруулах тэмцээнийг 2022 оны 05 дугаар сарын 04-нд 47 дахь жилдээ зохион байгууллаа.

Энэхүү уламжлалт тэмцээн нь 2 үе шаттай зохион байгуулагдаж, анхан шатны буюу дүүргүүдийн аварга шалгаруулах тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн дотор явагдаж бол нийт нийслэлийн 9 дүүргийн 65 цэцэрлэгийн 2000 гаруй хүүхэд оролцсон.

7.ГИМНАСТАРДА УРАЛДААНТ ҮЗЛЭГ

Иргэдийн бие бялдрыг гимнастикийн дасгал хөдөлгөөнөөр хөгжүүлэх, тэднийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор Гимнастрада уралдаант үзлэгийг 6 дахь жилдээ 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Монголын хөлбөмбөгийн холбооны футзааланд зохион байгууллаа.

Энэ удаагийн гимнастрада уралдаант үзлэгт Нийслэлийн 9 дүүргийн 56 байгууллагын 50 багийн 820 гаруй өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчид, ахмад настан оролцлоо.

8.”УЛААНБААТАР МАРАФОН-2022” ОЛОН УЛСЫН ГҮЙЛТ

Монгол улсад гүйлтийн спортыг хөгжүүлэх, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх, өсвөр, залуу үеийнхэнд өөрийн дотоод нөөц боломжийг нээж, зорилгодоо хүрэх тэсвэр хатуужил, бие бялдрын болон оюун санааны өв тэгш хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэдийг өдөр тутмын биеийн тамираар хичээллэх идэвх санаачилгыг дэмжих зорилгоор “Улаанбаатар марафон 2022” олон улсын гүйлтийг 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдөр 7 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Гүйлтийг 42,195м 18-аас дээш нас, 21,095м-ийн зайг 18-34, 35-54, 55-аас дээш нас, 10000м 18-аас дээш нас, 5000м-ийн зайг 12-17 нас, 18-аас дээш насны эрүүл мэндийн гүйлт, 1,500м /хараагүй, тэргэнцэртэй ХБИ, гэр бүл, тусгай олимпын хүүхдүүд/ гэсэн ангиллаар нийслэлийн иргэдээс гадна хөдөө, орон нутаг, монгол улсад ажиллаж, амьдарч байгаа гадаадын иргэд, хөрш зэргэлдээ орны гүйлт сонирхогчид болон олон улс, тив, дэлхийд танигдсан нэртэй тамирчид зэрэг **23690** иргэн бүртгүүлэн оролцсон.



9.”УЛААНБААТАР МАРАФОНД НЭГДЭЦГЭЭЕ” НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ЦОМ АЯЛУУЛАХ АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

“Улаанбаатар марафон 2022” олон улсын гүйлтийг амжилттай зохион байгуулах, оролцогч дэмжигчдийн тоог нэмэгдүүлэх, сурталчилгаа мэдээллийг өргөжүүлэх, бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллага, бүх шатны боловсрол, дүүрэг, хороо, аж ахуйн нэгжүүд, иргэдийг татан оролцуулахаар Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар марафонд нэгдэцгээе” цомын аяныг 2022 оны 03 дугаар сарын 28-наас 05 дугаар сарын 28-ны хооронд **60** хоногийн хугацаанд зохион байгуулсан.

10.ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН САГСАН БӨМБӨГИЙН БАГШ ДАСГАЛЖУУЛАГЧИЙН СУРГАЛТ

Ерөнхий боловсролын сургуулийн сагсан бөмбөгийн багш, дасгалжуулагчдыг чадавхжуулах, хамтын ажиллагааг сайжруулах, туршлага солилцох зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт цогцолборт зохион байгуулж 9 дүүргийн 54 сургуулийн 130 багш, дассгалжуулагчид хамрагдсан.

11.“УЛААНБААТАР МАРАФОН 2022” ОЛОН УЛСЫН ГҮЙЛТИЙН ШҮҮГЧДИЙГ БЭЛТГЭХ СУРГАЛТ

Монголын хэт холын марафон гүйлтийн холбоо, МУБИС-н Биеийн тамирын сургуультай хамтран “Улаанбаатар марафон 2022” олон улсын гүйлтийн шүүгч болон сайн дурын ажилчдыг бэлтгэх сургалт, семинарыг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж 100 шүүгч, оюунтнууд хамрагдлаа. Сургалтаар тэмцээний зохион байгуулалт, алдаа оноо, санамж, дүгнэлт, зөвлөгөө, хариуцлага, томилгооны асуудлуудыг хэлэлцэж, сургалтад хамрагдсан шүүгч, оюутнуудыг гүйлтийн ажиллагаанд гараа бариа, тойргийн шүүгч, сайн дурын ажилчдаар ажиллуулсан.

12.МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ “НИЙТИЙН ХӨЛБӨМБӨГ”-ИЙН ФЕСТИВАЛЬ

Нийтийн хөлбөмбөгийг нийслэлд хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Монголын Хөлбөмбөгийн холбоотой хамтран 2022 оны 5 дугаар сарын 08-18-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд болон нийслэлийн нутаг дэвсгэр ашиглагдаж байгаа хиймэл зүлэг бүхий хөл бөмбөгийн талбайд 10 өдрийн турш зохион байгуулсан. Энэ хүрээнд:

1.Сүхбаатарын талбайд 90х45м хэмжээтэй хөлбөмбөгийн хиймэл зүлгэн зөөврийн талбай байгуулж “Нийтийн хөл бөмбөг”-ийн фестивалийн нээлтийн ажиллагааг хийсэн.

2.Улаанбаатар хотын аварга шалгаруулах “UB CUP” хөлбөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж 200 гаруй тамирчид хамрагдсан. Тус тэмцээнд хөлбөмбөгийн лигийн тамирчид оролцохгүй.

3.Хөлбөмбөгийн дэлхийн од тамирчныг урьж оролцуулан уулзалт, сургалт, үзүүлэх тоглолт зохион байгуулсан.

4.Япон, Монгол улсын ахмадын хөлбөмбөгийн багийн нөхөрсөг тоглолт хийсэн.

5.Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт хөлбөмбөгийн сургалт зохион байгуулсан.

6.Нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа хиймэл зүлэг бүхий хөл бөмбөгийн 55 талбайд фестиваль зохион байгуулах хугацаанд хөлбөмбөг тоглох иргэдэд үнэ төлбөргүй үйлчилж ажилласан.

13.ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨРТ ЗОРИУЛСАН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан биеийн тамир, спортын арга хэмжээг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Д.Сүхбаатарын талбайд Монголын гимнастикийн холбоо, Монголын дугуй холбоо, Монголын Шатрын холбоо, Монголын Үндэсний шагайн наадгайн холбоо, Монголын Ширээний теннисний холбоотой хамтран зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр паркоур экстрим үзүүлбэрийн тэмцээн, шатар тэмцээн, үндэсний шагайн наадгай тэмцээн, ширээний теннис тэмцээн, дугуйн тэмцээн зохион байгуулж 610 хүүхэд багачуудыг оролцуулсан бол нээлтийн үеэр 8 цэцэрлэгийн 280 хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн үзүүлэх тоглолтыг хийж, хүүхэд бүрт гарын бэлэг гардуулсан.

14.“ДАНШИГ НААДАМ-ХҮРЭЭ ЦАМ” НААДМЫН ҮНДЭСНИЙ СУРЫН ХАРВААН ТЭМЦЭЭН

“Даншиг наадам-Хүрээ цам” наадмын үндэсний сурын харваа, үндэсний бөхийн барилдааныг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

15.НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН СПОРТЫН IV НААДАМ

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх, байгууллагуудын биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спортын IV наадмын шигшээ тэмцээнүүдийг 2022 оны 10 дугаар сарын 31-нээс 11 дүгээр сарын 07-ны өдрүүдэд спорт явган аялал, дартс, ажлын байрны дасгал, эрэгтэй, эмэгтэй сагсан бөмбөг, волейбол зэрэг спортын 5 төрлөөр 1-р шат – байгууллагын аварга шалгаруулах, 2-р шат – бүсийн аварга шалгаруулах, 3-р үе шат буюу Нийслэлийн шигшээ тэмцээн гэсэн 3-н үе шаттай зохион байгуулж, 100 байгууллагын 9560 албан хаагч хамрагдсан.

16.“УЛААНБААТАР СПОРТ” ӨДӨРЛӨГ

Иргэд, өсвөр үе, залуучуудыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороод, спортын холбоод, фитнесс, клубүүдийн үйл ажиллагаа сурталчилах зорилгоор “Улаанбаатар спорт” өдөрлөгийг 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 11.00-18.00 цагийн хооронд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Өдөрлөгт спортын үзүүлэх тоглолт болон 10 спортын төрлөөр 20 спортын уралдаан, тэмцээнийг зохион байгуулсан бол өдөрлөгт 5100 иргэд оролцож 25 төрлийн 1500 гарын авлага, брошуурыг хэвлэн тараасан.

17.НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН Х НААДАМ

Нийслэлийн Иргэдийн спортын Х наадам нь “Биеийн тамир, спортыг айл өрх, иргэн бүрт” зорилтын хүрээнд “Өдөр тутмын биеийн тамир – Өнөөгийн нийслэлчүүдийн өнгө төрх” гэсэн уриан дор явагдаж, багийн бүрэлдэхүүн тухайн хорооны иргэн байх, 31-ээс дээш настай байх, тухайн төрлийн спортын дэд мастераас дээш цолтой тамирчин 45-аас дээш настай байх, наадмын нэг төрөлд нэг тамирчин орох, шалгарсан баг тамирчид үндсэн бүрэлдэхүүнээрээ шат шатны тэмцээнд оролцох зэрэг нь бие бядрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх, хүн амыг биеийн тамир, спортын уралдаан тэмцээнд өргөнөөр хамруулах, иргэдийн идэвх санаачлагыг өрнүүлэх, хөршийн холбоог сайжруулах зэрэг онцлог шинжтэй үйл ажиллагаа юм. Арав дахь жилдээ зохион байгуулагдсан Нийслэлийн Иргэдийн спортын Х наадмын дүүргийн шатанд 9 дүүргийн 171 хорооны 88989 иргэнээс шалгарсан шилдгийн шилдэг 56 хорооны 106 багийн 1227 иргэн шигшээ тэмцээнд спортын 8 төрөлд 519 багц медалийн төлөө 2022 оны 07 дугаар сараас 11 дүгээр сарын 24-ний хооронд спортын 8 төрөл (спорт явган аялал, олс таталт, сагсан бөмбөг, волейбол, софт волейбол, хийн дасгал, аэробик, шагайн наадгай)-өөр 5 үе шат (хэсэг, хороо, бүс, дүүрэг, нийслэл)-тайгаар амжилттай зохион байгууллаа.

18.НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН Х НААДМЫН СПОРТ ЯВГАН АЯЛАЛЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Нийслэлийн Иргэдийн спортын Х наадмын спорт явган аялалын шигшээ тэмцээнийг 2022 оны 09 дүгээр сарын 10-11-ний өдрүүдэд “Улаанбаатар-Баянзүрх товчоо-Ургах наран хороолол-Баянзүрх хайрхан-Хар усан тохой” чиглэлд зохион байгуулж Нийслэлийн 8 дүүргийн 150 гаруй тамирчин, дасгалжуулагч, албаны хүмүүс оролцлоо.

19.НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН IV НААДМЫН ЯВГАН АЯЛАЛЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Спорт явган аялалын шигшээ тэмцээнийг 2022 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Хар усан тохойд амжилттай зохион байгуулж, нийт 8-н баг 96 албан хаагч хамрагдлаа.

Хэрэгжилт 100%

2.2.1.5.Өвлийн улиралд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг өргөжүүлнэ.

Нийслэлийн өвлийн наадмын нээлт “Цасны баяр” арга хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын 29-нд зохион байгуулахаар зааврыг батлуулж, төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэн бэлтгэл ажлыг хангасан боловч Коронавирус халдвар /Ковид-19/-ын Омикрон хувилбарын дэгдэлтээс шалтгаалан цуцлагдсан бол нийслэлийн 5 дүүрэгт 8 удаа өвлийн арга хэмжээг зохион байгуулж 131 байгууллагын **3672** иргэнийг хамруулсан. 2022 онд “Скай резорт” “Хандгайт-Янзага” “Мишээл экспо” цанын баазууд байгуулагдан **351,900** иргэдэд үйлчилгээ үзүүлж ажилласан байна.

А.Цанын бааз

№	Байгууллага	Үйл ажиллагааны чиглэл	Хамрагдагсдын тоо
1	Sky resort	Цана, снөүборд, чарга	130,000
2	Найрамдал	Цана, чарга	20,000
3	Хандгайт-Янзага зуслан	Цана, чарга	18,000
4	Мишээл экспо цанын бааз	Цана	6,300
5	Нийт		**174,300**

Б. Мөсөн гулгуурийн талбай /дотор, гадна/

№	Байгууллага	Үйл ажиллагааны чиглэл	Хамрагдагсдын тоо
1	Steppe arena	Чөлөөт гулгалт	112,000
2	Hunnu mall	Чөлөөт гулгалт	105,000
3	Тэшүүрийн талбай	Тэмцээн, чөлөөт	9,000
4	Жуков талбай	Чөлөөт гулгалт	4,500
5	6-р сургуулийн талбай	Чөлөөт гулгалт	1,800
6	Чингэлтэй дүүргийн БТСХорооны талбай	Хоккей, гулгалт	6,300
5	Нийт		**238,600**

Хэрэгжилт 100%

2.2.2.НИЙСЛЭЛД ҮНДЭСНИЙ СПОРТ БОЛОН БУСАД СПОРТЫН ТӨРЛҮҮДИЙГ ХӨГЖҮҮЛЖ, ТАМИРЧДЫН ЗАЛГАМЖ ХАЛААГ ТАСРАЛТГҮЙ БЭЛТГЭНЭ.

2.2.2.1.Багийн спортыг дэмжих замаар өсвөрийн хүүхэд, багачуудыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.

Багийн спортоор дамжуулан өсвөр үеийнхний бие бялдрыг хөгжүүлэх, хүмүүжил олгох, хамтач үзэл санааг төлөвшүүлэн сагсан бөмбөг, волейбол, хөлбөмбөг, 3х3, софт волейболийн тэмцээнүүдийг зохион байгуулж 1358 байгууллагын 145,200 иргэнийг хамруулсан.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ЕБС-ИЙН
СУРАГЧДЫН “УЛААНБААТАР ЛИГ”
САГСАН БӨМБӨГИЙН ШИГШЭЭ ФЕСТИВАЛЬ

ЕБС-ИЙН СУРАГЧДЫН “УЛААНБААТАР ЛИГ”
САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНИЙ
ДУНД НАСНЫ БАГУУДЫН ТОГЛОЛТЫН ДАРААЛАЛ

2022 оны 04 дүгээр сарын 22 Улаанбаатар хот

1.	СБД-ийн 1-р сургууль	- ЧД-ийн 72-р сургууль	- эм А
2.	БЗД-ийн 30-р сургууль	- БНД-ийн Гүн галуутай ЦС	- эм А
3.	СХД-ийн 42-р сургууль	- СБД-ийн 31-р сургууль	- эм В
4.	БГД-ийн Оюуны Үндрэл ЦС	- ХУД-ийн 52-р сургууль	- эм В
5.	БГД-ийн 40-р сургууль	- СБД-ийн 2-р сургууль	- эм С
6.	ЧД-ийн 24-р сургууль	- ХУД-ийн 32-р сургууль	- эм С
7.	БЗД-ийн 33-р сургууль	- СХД-ийн Өнөр ЦС	- эм D
8.	БЗД-ийн 44-р сургууль	- НД-ийн 109-р сургууль	- эм D
9.	СХД-ийн Өнөр ЦС	- БНД-ийн Гүн галуутай ЦС	- эр А
10.	БГД-ийн 40-р сургууль	- НД-ийн 119-р сургууль	- эр А
11.	БЗД-ийн 33-р сургууль	- БЗД-ийн 133-р сургууль	- эр В
12.	ХУД-ийн 52-р сургууль	- ХУД-ийн Орхон Хасу сургууль	- эр В
13.	ЧД-ийн 49-р сургууль	- СБД-ийн 31-р сургууль	- эр С
14.	СБД-ийн 2-р сургууль	- ЧД-ийн 23-р сургууль	- эр С
15.	БГД-ийн Оюуны Үндрэл ЦС	- БГД-ийн Эрдмийн өргөө ЦС	- эр D
16.	СХД-ийн Хөгжил ЦС	- БЗД-ийн 97-р сургууль	- эр D
17.	СБД-ийн 1-р сургууль	- БНД-ийн Гүн галуутай ЦС	- эм А
18.	БЗД-ийн 30-р сургууль	- ЧД-ийн 72-р сургууль	- эм А
19.	СХД-ийн 42-р сургууль	- ХУД-ийн 52-р сургууль	- эм В
20.	БГД-ийн Оюуны Үндрэл	- СБД-ийн 31-р сургууль	- эм В
21.	БГД-ийн 40-р сургууль	- ХУД-ийн 32-р сургууль	- эм С
22.	ЧД-ийн 24-р сургууль	- СБД-ийн 2-р сургууль	- эм С
23.	БЗД-ийн 33-р сургууль	- НД-ийн 109-р сургууль	- эм D
24.	БЗД-ийн 44-р сургууль	- СХД-ийн Өнөр ЦС	- эм D
25.	СХД-ийн Өнөр ЦС	- НД-ийн 119-р сургууль	- эр А
26.	БГД-ийн 40-р сургууль	- БНД-ийн Гүн галуутай ЦС	- эр А
27.	БЗД-ийн 33-р сургууль	- ХУД-ийн Орхон Хасу сургууль	- эр В
28.	ХУД-ийн 52-р сургууль	- БЗД-ийн 133-р сургууль	- эр В
29.	ЧД-ийн 49-р сургууль	- ЧД-ийн 23-р сургууль	- эр С
30.	СБД-ийн 2-р сургууль	- СБД-ийн 31-р сургууль	- эр С
31.	БГД-ийн Оюуны Үндрэл ЦС	- БЗД-ийн 97-р сургууль	- эр D
32.	СХД-ийн Хөгжил ЦС	- БГД-ийн Эрдмийн Өргөө ЦС	- эр D
33.	СБД-ийн 1-р сургууль	- БЗД-ийн 30-р сургууль	- эм А
34.	БНД-ийн Гүн галуутай ЦС	- ЧД-ийн 72-р сургууль	- эм А
35.	СХД-ийн 42-р сургууль	- БГД-ийн Оюуны Үндрэл ЦС	- эм В
36.	ХУД-ийн 52-р сургууль	- СБД-ийн 31-р сургууль	- эм В

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээнийг 2022 оны 03 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 30-ны хооронд 3 насны ангиллаар, 4 үе шаттай бага, дунд, ахлах насны ангиллаар амжилттай зохион байгууллаа. Анхан шатанд нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын 121 сургуулийн охид, хөвгүүдийн 6413 багийн 85000 мянга гаруй сурагч оролцсон бол Нийслэлийн шигшээ фестивалийг 2022 оны 04 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хороо, Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны “Спорт цогцолбор”-т зохион байгуулж шилдэг нийт 50 сургуулийн 96 багийн 1152 сурагч – тамирчин өрсөлдлөө.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ЕБС-ИЙН СУРАГЧДЫН “УЛААНБААТАР ЛИГ” ВОЛЕЙБОЛЫН ШИГШЭЭ ФЕСТИВАЛЬ

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” волейболын шигшээ фестивалийг 3 үе шаттай 2 насны ангиллаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын волейболын холбоотой хамтран 10 дахь жилдээ 2022 оны 05 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд зохион байгууллаа. Анхан шатны тэмцээнд Нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын 190 сургуулийн 9 дүүргийн ерөнхий боловсролын 190 сургуулийн 940 багийн 9454 сурагч, Нийслэлийн шигшээ тэмцээнд 38 сургуулийн 64 багийн 832 тамирчид оролцлоо.



Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар лиг" волейболын тэмцээний оноолт

2022 оны 04 дүгээр сарын 18 Улаанбаатар хот

Насны ангилал: **Ахлах нас Хөвгүүд**

А хэсэг

№	Дүүрэг, сургууль	Багийн нэр	1	2	3	4	Оноо	Байр
1	ХУД	7-р сургууль	✓					
2	ХУД	"Орчлон" Олон улсын сургууль		✓				
3	БГД	51-р сургууль			✓			
4	СХД	2-р баг				✓		

В хэсэг

№	Дүүрэг, сургууль	Багийн нэр	1	2	3	4	Оноо	Байр
1	СБД	1-р сургууль	✓					
2	ЧД	50-р сургууль		✓				
3	СБД	"Логарифм" сургууль			✓			
4	БХД	"Хамгаа" цэнтрлэгдэр сургууль				✓		

С хэсэг

№	Дүүрэг, сургууль	Багийн нэр	1	2	3	4	Оноо	Байр
1	БГД	"Шинэ Эрин"	✓					
2	БЗД	21-р сургууль		✓				
3	БГД	20-р сургууль			✓			
4	НД	"Эрдмийн Оргил" цс				✓		

D хэсэг

№	Дүүрэг, сургууль	Багийн нэр	1	2	3	4	Оноо	Байр
1	БНД	"Оюунн Эрин" ЦС	✓					
2	ЧД	24-р сургууль		✓				
3	СХД	1-р баг			✓			
4	БЗД	97-р сургууль				✓		

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар лиг"

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ “НИЙТИЙН ХӨЛБӨМБӨГ”-ИЙН ФЕСТИВАЛЬ

Нийтийн хөлбөмбөгийг нийслэлд хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Монголын Хөлбөмбөгийн холбоотой хамтран 2022 оны 5 дугаар сарын 08-18-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд болон нийслэлийн нутаг дэвсгэр ашиглагдаж байгаа хиймэл зүлэг бүхий хөл бөмбөгийн талбайд 10 өдрийн турш зохион байгуулсан. Энэ хүрээнд:

1.Сүхбаатарын талбайд 90х45м хэмжээтэй хөлбөмбөгийн хиймэл зүлгэн зөөврийн талбай байгуулж “Нийтийн хөл бөмбөг”-ийн фестивалийн нээлтийн ажиллагааг хийсэн.

2.Улаанбаатар хотын аварга шалгаруулах “UB CUP” хөлбөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж 200 гаруй тамирчид хамрагдсан. Тус тэмцээнд хөлбөмбөгийн лигийн тамирчид оролцохгүй.

3.Хөлбөмбөгийн дэлхийн од тамирчныг урьж оролцуулан уулзалт, сургалт, үзүүлэх тоглолт зохион байгуулсан.

4.Япон, Монгол улсын ахмадын хөлбөмбөгийн багийн нөхөрсөг тоглолт хийсэн.

5.Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт хөлбөмбөгийн сургалт зохион байгуулсан.

6.Нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа хиймэл зүлэг бүхий хөл бөмбөгийн 55 талбайд фестиваль зохион байгуулах хугацаанд хөлбөмбөг тоглох иргэдэд үнэ төлбөргүй үйлчилж ажилласан.

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН “UB CUP” ХӨЛ БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын аварга шалгаруулах “UB Cup 2022” хөлбөмбөгийн тэмцээнийг Монголын хөлбөмбөгийн холбооны шинэ Яармагийн талбайд анх удаагаа зохион байгуулж 9 дүүргийн 214 тамирчид оролцсон.

Хэрэгжилт 100%

2.2.2.2.Биеийн тамир, спортын төрийн болон төрийн бус байгууллагуудын түншлэлд тулгуурлан спортын уралдаан тэмцээнүүдийн чанар зохион байгуулалтыг сайжруулна.

Спортын уралдаан, тэмцээнд мэргэжлийн шүүгч ажиллуулан, тэмцээн уралдааныг өндөр түвшинд зохион байгуулснаар тухайн спортын төрлийг хөгжүүлж, тамирчдын чансааг тогтоон, бүсийн болон улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх олгон төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, дэмжих зорилгоор спортын төрлүүдийг дагнан хөгжүүлдэг 13 холбоотой хамтран ажиллах, ажил гүйцэтгэх гэрээ байгуулан Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг спортын уралдаан тэмцээнийг 15 удаа зохион байгуулж 446 байгууллагын 7888 тамирчинг хамруулсан.

1.УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ПАРА БАДМИНТОНЫ ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын аварга шалгаруулах пара бадминтоны тэмцээнийг 2022 оны 09 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд Баянгол дүүргийн 70-р сургуулийн спорт зааланд Монголын пара бадминтоны “Эрч хүч” холбоотой хамтран зохион байгууллаа. Тэмцээнд өсвөр үе, насанд хүрэгчид гэсэн ангиллаар 6 дүүргийн 23 тамирчин оролцлоо.

2.УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ПАРА БОЧИГИЙН ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын аварга шалгаруулах Пара бочигийн тэмцээнийг 2022 оны 09 дүгээр сарын 29-30-ны өдрүүдэд Баянгол дүүргийн 70-р сургуулийн спорт зааланд Монголын пара бочигийн холбоотой хамтран зохион байгуулсан. Тус тэмцээнп 8 багийн 50 тамирчид авхаалж, хурд хүчээ сорин өрсөлдлөө.

3.УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ БАДМИНМОНЫ ТЭМЦЭЭН

Монголын бадминтон сонирхогчдын холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах бадминтоны тэмцээнийг 2022 оны 10 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд Налайх дүүргийн 353 дугаар цэргийн ангийн спорт зааланд зохион байгуулж 4 насны ангиллаар 141 тамирчид оролцлоо.

4.УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ХОНХТОЙ БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН

Монголын Хонхтой бөмбөгийн холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах хонхтой бөмбөгийн тэмцээнийг 2022 оны 10 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд Монголын хараагүйчүүдийн холбооны спорт зааланд зохион байгуулж 130 тамирчид оролцлоо.

5.УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ШАТРЫН ТЭМЦЭЭН

Монголын шатрын холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах шатрын тэмцээнийг 2022 оны 10 дугаар сарын 08-09-ны өдрүүдэд Баянгол дүүргийн “Монгени” сургуулийн спорт зааланд зохион байгуулж 5 насны ангиллаар 19 байгууллагын 330 тамирчид оролцлоо.

6.УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЖҮДО БӨХИЙН ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын аварга шалгаруулах Жүдо бөхийн өсвөр үеийн тэмцээнийг Монголын Жүдо бөхийн холбоотой хамтран 2022 оны 02 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд Спортын төв ордонд зохион байгуулж бага, дунд, ахлах насны 34 байгууллагын 990 тамирчин өрсөлдсөн.

Энэхүү тэмцээнд амжилттай оролцож жин тус бүрдээ 1-8 дугаар байрт шалгарсан тамирчид жүдо бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх олголоо.

7.УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын аварга шалгаруулах ширээний теннисний өсвөр үеийн тэмцээнийг Монголын Ширээний теннисний холбоотой хамтран “Оч” клуб дээр 2022 оны 03 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Тус тэмцээнд охид, хөвгүүд 4 насны ангиллаар ганцаарчилсан болон багийн төрөлд нийт 235 тамирчид оролцож ур чадвараа сорин өрсөлдөн багийн төрөлд эхний 4, ганцаарчилсан төрөлд эхний 7 байр эзэлсэн баг тамирчдад 2022 оны ширээний теннисний улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх олголоо.

8.УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЗАСМАЛ ЗАМЫН ДУГУЙН ТЭМЦЭЭН

Монголын Дугуйн холбоотой хамтран 2022 оны 05 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд дугуйн спортын нэрт дасгалжуулагч, спортын мастер Н.Нармандах агсаны нэрэмжит Улаанбаатар хотын аварга шалгаруулах Засмал дамын дугуйн тэмцээнийг Хүй долоон худагт “Монгол наадам цогцолбор”-ын зам дээр 20 насны ангилалд 15 км-ын зайд ганцаарчилсан гараатай, 30, 60, 80 км-ын зайд бөөн гараатай зохион байгууллаа. Тэмцээнд давхардсан тоогоор 47 байгууллагын 213 тамирчид ур чадвараа сорин өрсөлдлөө.

9.УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ БАЙТ ХАРВААНЫ ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын аварга шалгаруулах Байт харвааны XXI удаагийн тэмцээнийг Монголын Байт харвааны холбоо хамтран 2022.06.04-05.ны өдрүүдэд "Дайчин Чанар-Тэсвэрийн Талбар” 360 талбайд зохион байгуулж 70 гаруй тамирчид рекурв, компаундын төрлөөр 6 багц медалийн төлөө цэц мэргэнээ сорин өрсөлдлөө.

10.УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ СОФТ ТЕННИС

Монголын софт теннисний холбоотой хамтран 2022 оны 06 дугаар сарын 17-19-ны өдрүүдэд софт теннисний төв талбайд 7-10 нас, 11-12 нас, 13-15 нас, 16-18 нас гэсэн 4 ангиллаар охид, хөвгүүдийн ганцаарчилсан, хос, холимог хос болон багийн гэсэн 7 төрлөөр зохион байгуулж 12 байгууллагуудын 320 гаруй өсвөрийн теннисчид оролцлоо.

11.ҮНДЭСНИЙ СУРЫН ХАРВААНЫ УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын аварга шалгаруулах 2022 оны харваанд нийт 245 харваачаас 79 эмэгтэй 166 эрэгтэй харваач оролцож 2022 оны 05 сарын 28-29-ний өдрүүдэд ажилттай явагдаж өндөрлөсөн.

12.УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ СПОРТ АВИРАЛТЫН ТЭМЦЭЭН

Улаанбаатар хотын 2022 оны аварга шалгаруулах спорт авиралтын тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд Монголын уулчдын холбоотой хамтран зохион байгуулж 150 тамирчин 30 багц медалийн төлөө хурдны авиралт болон техникийн авиралтын гэсэн хоёр төрлөөр өрсөлдөж дүнгээ гаргалаа.

13.УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДҮҮДИЙН УРАН ХӨДӨЛГӨӨНТ ГИМНАСТИК

Сургуулийн өмнөх насны хүүхдийн бие бялдрыг гимнастикийн дасгал хөдөлгөөнөөр хөгжүүлэх, тэднийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор цэцэрлэгийн хүүхдүүдийн Уран хөдөлгөөнт гимнастикийн аварга шалгаруулах тэмцээнийг 2022 оны 05 дугаар сарын 04-нд 47 дэх жилдээ зохион байгууллаа.

.

Энэхүү уламжлалт тэмцээн нь 2 үе шаттай зохион байгуулагдаж, анхан шатны буюу дүүргүүдийн аварга шалгаруулах тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн дотор явагдаж бол нийт нийслэлийн 9 дүүргийн 65 цэцэрлэгийн 2000 гаруй хүүхэд оролцсон.

14.НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ЕБС-ИЙН
СУРАГЧДЫН “УЛААНБААТАР ЛИГ” САГСАН БӨМБӨГИЙН ШИГШЭЭ ФЕСТИВАЛЬ

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн шигшээ фестивалийг дүүргийн Биеийн тамир, спортын хороод, Монголын Спортын шүүгчдийн холбоотой хамтран 2022 оны 03 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 30-ны хооронд 3 насны ангиллаар шилдэг нийт 50 сургуулийн 96 багийн 1152 сурагч – тамирчин өрсөлдлөө. зохион байгууллаа.

15.НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ЕБС-ИЙН
СУРАГЧДЫН “УЛААНБААТАР ЛИГ” ВОЛЕЙБОЛЫН ШИГШЭЭ ФЕСТИВАЛЬ

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” волейболын шигшээ фестивалийг 2 насны ангиллаар Монголын волейболын холбоотой хамтран 10 дахь жилдээ 2022 оны 05 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд зохион байгуулж 38 сургуулийн 64 багийн 832 тамирчид оролцлоо.

Хэрэгжилт 100%

2.2.2.3. Олон улсын залуучуудын ногоон наадмыг зохион байгуулна.

Олон улсын Залуучуудын ногоон наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд “Улаанбаатар -2023” Зүүн Азийн Залуучуудын наадмын бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлж хөлбөмбөгийн ногоон талбай бүхий техникийн төв 98 хувьтай, Спортын ордон бэлтгэлийн төв 80 хувьтай үргэлжилж байна. “Коронавируст халдвар /Ковид-19/”-аас сэргийлэх цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан “Олон улсын залуучуудын ногоон наадам”-ыг Монгол улсын Засгийн газрын 2021 оны 147 дугаар тогтоолоор 2025 онд зохион байгуулахаар хойшлуулсан.

Хэрэгжилт 90%

2.2.2.4. Зүүн Азийн Залуучуудын Анхдугаар наадмыг өндөр түвшинд зохион байгуулна.

ХӨЛБӨМБӨГИЙН НОГООН ТАЛБАЙТАЙ ТЕХНИКИЙН ТӨВИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ЯВЦ

“Улаанбаатар -2023” Зүүн Азийн залуучуудын наадмын хүрээнд хөлбөмбөгийн талбай бүхий техникийн төв нь 109х74м хэмжээтэй бүрэн автомат усалгааны системээр тоноглогдсон, 300 LUX хүчин чадалтай 4 гэрэлтүүлэгч буюу прожектортой байх бөгөөд үзэгчийн суудал- 500 хүн, хувцас солих өрөө-4 ш /тус бүр 30 хүний багтаамжтай/, ариун цэврийн өрөө- 5ш, нийтийн ариун цэврийн өрөө-4, шүүгчийн өрөө- 2ш, эмчийн өрөө-1, допинг шалгах өрөө-1, хэвлэлийн бага хурлын өрөө- 1ш / 50 хүний багтаамжтай/, монголын Хөл бөмбөгийн холбооны ажилчдын өрөө- 1ш, хүлээлгийн хэсэг- 1ш- с бүрдэхээр төлөвлөсөн байгууламж юм.

Барилга угсралтын ажил бүрэн дууссан, гадна шугам сүлжээ /дулаан, цэвэр, бохир/, цахилгаан, холбоо дохиоллын эх үүсвэрт холбох ажил хүлээгдэж байна.

Гүйцэтгэгч:	"ӨВМТХ" ХХК
Гэрээ байгуулсан огноо:	2020.03.09
Гэрээний дугаар:	№21
Гэрээний дүн:	11 377 727 637
Улаанбаатар Спорт Менежмент ХК	5 684 410 148
ОУ хөлбөмбөгийн холбоо	5 693 317 489
Ажлын явц:	98%

СПОРТЫН ТӨВ (БЭЛТГЭЛИЙН ОРДОН)-НЫ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Олон улсын стандартад нийцсэн спортын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, нийт 2029 үзэгчдийн суудалтай, 120 хүний VIP үзэгчдийн суудал, 100 хүн хүлээн авах хүчин чадалтай фитнес заал, 200 хүн хүлээн авах хүчин чадалтай ресторан, 100 хүний суудалтай хурлын заал, 14 өрөө бүхий 60 ортой зочид буудал, оффисын 14 өрөө, тусгай зочдын 3 өрөө, тамирчдын 4 хувцас солих хөрөө, 22 авто машины дулаан гараашш, 300 авто машины гадна ил зогсоолтой байхаар төлөвлөсөн зоорьтой 3 давхар барилгын Спортын төвийн барилгын гадна сэндвич хавтангийн угсралт 100%, ханын өрлөг 100%, шилэн фасад 100%, дотор сантехник болон цахилгааны шугамын угсралт 70%, Нийт ажлын бодит гүйцэтгэл 80%-тай байна.

Хэрэгжилт 100%

2.2.2.5. Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж дэмжлэг үзүүлнэ.

Тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх зорилтын хүрээнд 9 дүүргийн Засаг даргын дэргэд өсвөрийн шигшээ багуудыг спортын **24** төрлөөр **65** багт 101 дасгалжуулагч, 2856 тамирчдын бүрэлдэхүүнтэй байгуулан сургалт, дасгалжуулалтад хамруулж байна. Уралдаан тэмцээнд амжилт үзүүлэх нөхцөлийг бүрдүүлснээр өсвөрийн шигшээ багын тамирчид 554 удаагийн тэмцээнд оролцож тив, улс, хот, нэрэмжит тэмцээнүүдээс 1335 медаль хүртсэн амжилт гаргаад байна.



ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН ДЭРГЭДЭХ ӨСВӨРИЙН ШИГШЭЭ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН /2020 он/

№	Спортын төрөл	Баганууд			Багахангай			Баянгол			Баянзүрх			Налайх			Сухбаатар			Сонгинохайрхан			Хан-Уул			Чингэлтэй			НИЙТ ДҮН		
	Он	Спортын танхимын тоо	Дасгалжуулагчдын тоо	Тамирчдын тоо	Спортын танхимын тоо	Дасгалжуулагчдын тоо	Тамирчдын тоо	Спортын танхимын тоо	Дасгалжуулагчдын тоо	Тамирчдын тоо	Спортын танхимын тоо	Дасгалжуулагчдын тоо	Тамирчдын тоо	Спортын танхимын тоо	Дасгалжуулагчдын тоо	Тамирчдын тоо	Спортын танхимын тоо	Дасгалжуулагчдын тоо	Тамирчдын тоо	Спортын танхимын тоо	Дасгалжуулагчдын тоо	Тамирчдын тоо	Спортын танхимын тоо	Дасгалжуулагчдын тоо	Тамирчдын тоо	Спортын танхимын тоо	Дасгалжуулагчдын тоо	Тамирчдын тоо	Спортын танхимын тоо	Дасгалжуулагчдын тоо	Тамирчдын тоо
6	Даам/Зуун буудалт даам										1	1		1	1								1	1		1	1		4	4	0
7	Дүүй							1	1											1	1	15							2	2	15
8	Жудо бөх				1	1		1	1		1	1					1	1		1	1	18	1	1		1	1		7	7	18
9	Крикет																						1	1					1	1	0
10	Сагсан бөмбөг	1	1		1	1		1	1		1	1		1	1		1	1		1	1	99	1	1		1	1		9	9	99
11	Самбо бөх										1	1																	1	1	0
12	Софт теннис																						1	1		1	1		2	2	0
13	Спорт бүжиг							1	1																				1	1	0
14	Спортын гимнастик										1	1								1	1	60				1	1		3	3	60
15	Таэквондо							1	1					1	1														2	2	0
16	Тэшүүр										1	1											1	1		1	1		3	3	0
17	Уран сайхны гимнастик							1	1																				1	1	0
18	Усанд сэлэлт	1	1																										1	1	0
19	Үндэсний бөх	1	1																										1	1	0
20	Хөл бөмбөг	1	1											1	1								1	1		1	1		4	4	0
21	Хөнгөн атлетик													1	1					1	1	30							2	2	30
22	Челөөт бөх	1	1		1	1		1	1		1	1		1	1		1	1		1	1	30	1	1					8	8	30
23	Шатар	1	1					1	1					1	1											1	1		4	4	0
24	Ширээний теннис				1	1		1	1		1	1		1	1								1	1		1	1		6	6	0
	ДҮН:	7	7	136	6	6	120	12	12	198	12	12	192	10	10	122	4	4	40	9	9	357	10	10	366	11	11	283	81	82	1814

Хэрэгжилт 100%

2.2.3.Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.2.3.1. Олон улсын жишигт нийцсэн 30,000-40,000 хүний суудалтай шинэ цэнгэлдэх хүрээлэнг шинээр барина.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1046 дугаар “Газар эзэмших эрх олгох тухай” захирамжаар Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрших 30.0 га газарт “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн” байгуулах зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт олгосон боловч тухайн газар Байгаль орчны яаманд олгосон газруудтай давхцалтай байсан тул

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 07 тоот тушаал, Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны 36 тоот тушаалаар дэд ажлын хэсгүүд байгуулагдан газрын маргаан, зөрчлийг шийдвэрлэхээр ажиллаж байгаа ч бүрэн шийдвэрлэгдээгүй байна.“Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн”-гийн зураг төсөв хийх ажлын зардал 2022 оны улсын төсөвт 500.0 төгрөг тусгагдсаны дагуу тус ажлыг гүйцэтгэх байгууллагын жагсаалтыг гаргасан.

Хэрэгжилт 30%

2.2.3.2. Нийслэл болон Чингэлтэй, Баянгол, Баянзүрх, Налайх, Сүхбаатар дүүргүүдийн спорт цогцолборуудын барилгын гүйцэтгэл 76 хувьтай байна.

Нийслэл болон 6 дүүргийн спорт цогцолборыг барих ажил 71.4 хувь (Чингэлтэй -100%, Баянгол -100%, Налайх -95%, Нийслэл-40%, Сүхбаатар-40%, Баянзүрх 85%, Багахангай-40%)-тай үргэлжилж байна.

1. Сүхбаатар дүүргийн спорт цогцолборын нийт өртөг 9.936,8 сая төгрөг өмнөх онуудад 2800.0 сая төгрөгийн санхүүжилт авсан. 2020 оны төсөвт 4,2 тэрбум төгрөг улсын төсөвт тусгагдсан боловч нь “ковид-19” цар тахлын улмаас ажил хийгдээгүй тул буцаж татагдсан. 2021 онд улсын төсөвт 1.500,0 сая төгрөг тусгагдсан. Үлдэгдэл санхүүжилт 5.636.8 сая төгрөг байна.

Барилга угсралтын ажил 40%-тай.

2.Налайх дүүргийн спорт цогцолборын нийт өртөг 13.497,7 сая төгрөг бөгөөд “Бүрд констракшн” ХХК дулааны ЦТП барих ажлыг дуусган гадна дулааны шугамын ажил үргэлжилж байна.

Барилга угсралтын ажил 95%-тай.

3.Баянзүрх дүүргийн спорт цогцолборын гүйцэтгэл 85%-тай үргэлжилж байна.

4.Багахангай дүүргийн спорт цогцолборын барилгын 40%-ийг “Алтан шар говь” ХХК гүйцэтгээд байна.

5. Нийслэлийн спорт цогцолборын гүйцэтгэгч “Үүрэг трейд” ХХК огторгуйн хийцэл бүхий тусгай зориулалтын дээврийг БНХАУ руу захиалсан нь хүлээгдэж байгаа тул барилгын ажлыг эхлүүлээгүй гүйцэтгэл нь 40%-тай байна.

6.Баянгол дүүргийн спорт цогцолборыг “Молор констракшн” ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсныг тус дүүргийн засаг даргын 2022 оны А/86 дугаар захирамжаар Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хороо хүлээн авч үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

2.2.3.3. Нийслэлийн дэд төвүүдэд биеийн тамир спортын барилга байгууламж, төрөлжсөн задгай талбайг төлөвлөх, барих асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

Спорт цогцолборын барилга байгууламжын нэг маягийн эх загвар зургийг “Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн багтай хамтран зургийн даалгаврыг гарган өгч Бодь Пропертийз ХХК-иар хийлгэж 2020 онд батлуулсан. Дээрх нэг маягийн эх загвар зургаар Сонгинохайрхан дүүргийн Баянхошуу дэд төв, Баянзүрх дүүргийн Шар хад дэд төв, Сүхбаатар дүүргийн Дамбадаржаа дэд төвүүдийн спорт цогцолборуудыг барихаар төлөвлөсөн.

Үүнээс:

1. Баянхошуу дэд төв: Сонгинохайрхан дүүргийн 40 дүгээр хороонд баригдах 650 хүний суудалтай спорт цогцолборын барилгын гүйцэтгэгч байгууллага болох “Стандарт холдинг” ХХК, “Химон констракшн” ХХК болон “Таны зам” ХХК-ын 2021 онд гүйцэтгэгч байгууллагаар шалгарч 2022 онд 3 блокын суурийн ажлыг бүрэн хийж дуусган, зоорын давхрын цутгалтыг хийн барилгын нийт ажлын 50 хувийг гүйцэтгээд байна.

(Хэрэгжилт 70%)

2. Шархад дэд төв: Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороонд баригдах 400 хүний суудалтай спорт цогцолборын газрын асуудал шийдэгдэж, зураг төсөл, төсөв бүрэн хийгдсэн боловч хөрөнгийн асуудал шийдэгдээгүй улмаас хүлээгдэж байна.

(Хэрэгжилт 70%)

3. Дамбадаржаа дэд төвд шинээр баригдах спорт цогцолборын зураг төсөл хийгдсэн боловч барилга барих газрын асуудал шийдэгдээгүй улмаас хүлээгдэж байна.

(Хэрэгжилт 70%)

2.2.3.4. Биеийн тамир, спортын хуучин талбайнуудыг эзэмшиж байгаа иргэн, аж ахуй нэгжтэй зөвшилцөн эргүүлэн авах, уг талбайнуудыг нийтийн эдэлбэр газраар үлдээж, сэргээн засна.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/447 дугаар захирамжаар Нийслэлд биеийн тамир, спортын зориулалтаар ашиглагдаж байгаад иргэд, аж ахуй нэгжид шилжсэн талбайг нийтийн эдэлбэр газраар нь үлдээж, зориулалтын дагуу ашиглах, сэргээн засварлах, дүгнэлт гаргах ажлын хэсэг холбогдох судалгааг бүрэн хийж дараах бүртгэлийг гаргасан.

- Хан-Уул дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр хуучнаар Ээрмэлийн стадион байсан газар дээр “Ариг гал” ХК-д үйлдвэрлэлийн зориулалтаар олгогдсон 11243мкв
- Хан-Уул дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр хуучнаар Ээрмэлийн стадион байсан газар дээр “Камдер” ХХК-д үйлдвэрлэлийн зориулалтаар олгогдсон 11800мкв талбай
- Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн хуучин стадионы талбай
- Сонгинохайрхан дүүргийн 40 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах СХД-н Онцгой байдлын хэлтэст “Гал түймэр унтраах, аврах анги сургалтын төв”-ийн зориулалтаар олгогдсон 38805мкв
- Сонгинохайрхан дүүргийн 40 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Нийслэлийн Онцгой байдлын газарт “Спорт цогцолбор”-ын зориулалтаар олгогдсон 18832мкв талбайнууд одоогоор барилга байгууламж баригдаагүй, хоосон байна.









Хэрэгжилт 100%

2.2.3.5. Ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамир спортын талбайнуудыг стандартын дагуу тохижуулах, аж ахуйн нэгжид олгосныг цуцалж, сургуулийн эзэмшил газарт нь нэмж баталгаажуулна.

Нийслэлийн ЕБС-иудын биеийн тамир, спортын гадна талбайн судалгааг 2021 онд бүрэн хийж дуусган түүнд үндэслэн 2022 онд СБД-н 2, ХУД-н 34, 52 дугаар сургуулийн гадна талбайг дүүргийн ЗДТГ-н санхүүжилтийг олгуулж суурийн ажлыг гүйцэтгэн, Монголын хөл бөмбөгийн холбоотой хамтран ОУ-ын стандарт шаардлага хангасан хөлбөмбөгийн хиймэл зүлгээр сольж, иж бүрэн тохижилтыг хийсэн.

Хэрэгжилт 100%

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөнд Биеийн тамир, спортын чиглэлээр туссан 3 зорилт 15 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 92 хувьтай байна.

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА Ж.ГАНБОЛД

ТАЙЛАН ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН Г.БЯМБАСАЙХАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭР
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН А.НАМУУН